



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
ДҮГНЭЛТ

2025 оны 3 дугаар сарын 24

дугаар 1111

Улаанбаатар хот

Г Тамга, тэмдгийн хяналтын
дугаар хүчингүй болгох тухай

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.7.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/341 дүгээр тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам”-ын 14-д заасныг тус тус ҮНДЭСЛЭХ нь:

Голден Наат ХХК (6248144)-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ямпилын гаргасан хүсэлтэд “Манай Голден Наат ХХК нь тамга, тэмдгээ хаяж үрэгдүүлсэн тул хяналтын дугаар шинээр олгож өгнө үү.” гэсний дагуу мэдээллийн санд бүртгэлийг хянаад ТОДОРХОЙЛОХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд Голден Наат ХХК-нд 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэгч Д.Гангамэрэн 1117253290 хяналтын дугаар олгосон бүртгэл, Монгол Улсын иргэн Ц.Ямпил 100 хувийн хувьцаа эзэмшиж байна. Гүйцэтгэх удирдлагаар Ц.Ямпил бүртгэлтэй байх бөгөөд өнөөдрийн байдлаар тус хуулийн этгээдэд хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн хоригийн бүртгэл бүртгэгдээгүй байна.

2.Голден Наат ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Ямпилын гаргасан хүсэлт, түүнд хавсаргаж өгсөн нотлох баримтыг хянан үзэхэд: Сүхбаатар дүүргийн 6 дугаар хороо, 73/11 байр 15 тоот хаягт байршилтай, Голден Наат ХХК-ийн тамга, тэмдгийн хяналтын 1117253290 дугаартай тэмдгийг гээгдүүлсэн тухай 2025 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчийн шийдвэр, түүнд гүйцэтгэх захирал Ц.Ямпилын гарын үсэгтэй, 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн гүйцэтгэх захирал Ц.Ямпилын гарын үсэгтэй хүсэлт, Зууны мэдээ сонины 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн №51(7548) дугаарт хүчингүйд тооцсон тухай зар зэрэг нотлох баримтаар Голден Наат ХХК нь тамга, тэмдгийн хяналтын 1117253290 дугаартай тэмдгийг гээсэн болох нь нотлогдож байна.

3.Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Голден Наат ХХК-ийг 500 нэгжээр торгож, энэ хуулийн 3.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 250 нэгжээр хөнгөрүүлж, торгож шийтгэл оногдуулсан тухай Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хяналтын улсын байцаагчийн 0920339 дугаартай шийтгэлийн хуудас байна.

15250130025

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1-т “Хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах” гэж, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсэгт “Тамга, тэмдэг устсан, түүнийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүйд тооцож, хяналтын дугаарыг улсын бүртгэгч ажлын 2 өдрийн дотор дахин олгоно.” гэж заасныг тус тус баримтлан ДҮГНЭХ нь:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд 6248144 регистрийн дугаартай Голден Наат ХХК-д олгосон тамга, тэмдгийн хяналтын 1117253290 дугаарыг хүчингүй болгох.

2.Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу Голден Наат ХХК-д мэдэгдэх.

3.Байгууллагын цахим сайтад байршуулах арга хэмжээ авах.

Дүгнэлтийн хувийг Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн улсын бүртгэлийн тасагт хүргүүлэх.

ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

М.МОНХГЭРЭЛ

